



ДУНДГОВЬ АЙМАГ
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 9/5

Тавин

“3000 уртын дуучид, морин хуурчид”-ын
наадамд оролцох бэлтгэл хангах
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалт, “Морин хуураа дээдлэн дэлгэрүүлэх тухай” Ерөнхийлөгчийн 2002 оны 17 дугаар зарлиг, Уртын дуугаа өвлөн дэлгэрүүлэх тухай Ерөнхийлөгчийн 2004 оны 134 дүгээр зарлиг, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.3.3 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2023 оны 03 сарын 22-ны өдрийн А/150 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Уяхан замбуу тивийн наран” 3000 уртын дууч, морин хуурчдын эвент наадмыг зохион байгуулах комиссыг дараахи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ч.Оюунцэцэг (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Ж.Эрдэнэцэцэг (Соёлын төвийн эрхлэгч)

Гишүүд: Г.Уранбилэг (Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга)

Б.Уранцэцэг (Тамгын газрын дарга)

Э.Баяржаргал (Санхүүгийн албаны дарга)

Б.Загдзүсэм (Нийгмийн бодлого хариуцсан

мэргэжилтэн)

С.Отгонбаяр (Эрүүл мэндийн төвийн даргын албан

үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Уугансарнай (Цэцэрлэгийн эрхлэгч)

Б.Даваажаргал (Дунд сургуулийн захирлын үүргийг

түр орлон гүйцэтгэгч)

Ж.Батжаргал (1 дүгээр багийн Засаг дарга)

Ю.Туяамаа (2 дугаар багийн Засаг дарга)

Б.Төмөрчөдөр (3 дугаар багийн Засаг дарга)

Э.Сэржмядаг (4 дүгээр багийн Засаг дарга)

Ё.Адилбиш (5 дугаар багийн Засаг дарга)

Ж.Жавзандулам (Сургуулийн дуу хөгжмийн багш)

Н.Амгаланболд (Соёлын төвийн хөгжмийн багш)

Ч.Бүтэнсайхан (Ахмадын хорооны дарга)

2. 3000 уртын дуучид, морин хуурчдын наадамд сумаас уртын дууч 110, морин хуурч 30-ыг бэлтгэн оролцуулсугай.

3. Дээрх арга хэмжээнд оролцож байгаа иргэдэд Уяхан замбуу тивийн наран, Энх мэндийн баяр, Оломгүй далай морин хуурын аялгуу, Дундговийн магтаал, миний нутгийн бараа, төв халх жонон зэрэг уран бүтээлүүдийг зааж сургахыг комиссын дарга гишүүдэд үүрэг болгосугай.

4. Бэлтгэл ажлыг ханган гүйцэтгэх үүргийг тодорхойлж төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллахыг комиссын дарга (Ч.Оюунцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.УРАНЧИМЭГ